



МОНГОЛЫН
Дотоодын
Хэрэг
Яамны
Хууль
Сахиулах
Урьдчилсан
Төвлөлийн
Хурал

КИБЕР ОРЧИНД ТЕЛЕГРАМ ПЛАТФОРМ АШИГЛАН ҮЙЛДЭЖ БУЙ ЗАЛИЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

THE SITUATION OF FRAUD CRIMES USING THE TELEGRAM PLATFORM IN THE CYBER ENVIRONMENT

Б.Хатанзориг

Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын
Цахим мэдээлэл, дүн шинжилгээний хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөгч

Khatanzorig B.

Senior Criminal detective, Department of Digital Information & Analysis,
Cybercrime Division, Criminal Police Agency

*Хариуцлагатай зохиогч: KhatanzorigB@gmail.com

Хураангуй: Дэлхий дахинд орчин үеийн техник, технологи хөгжиж, нийгмийн бүхий л харилцаа цахим хэлбэрт шилжихийн хэрээр хүн төрөлхтөний цахим орчны хэрэглээ өсөн нэмэгдэж нийгэмд хөгжлийн шинэ боломж олгохын зэрэгцээ сөрөг үзэгдлүүдийг ч дагуулсаар байна. Үүний нэг илрэл нь кибер орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг юм.

Кибер орчин ашиглан үйлдэгдэж буй гэмт хэрэг нь зах хязгааргүй интернэт орчноор дамжин үйлдэгддэг тул манай улсад мөн адил тус төрлийн гэмт хэрэг ихээр үйлдэгдэж, маш эрчимтэй хувьсан өөрчлөгдөж, шинэ үйлдлийн аргууд тогтмол илэрч байгаа билээ.

Сүүлийн үед Монгол улсад “Телеграм” платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг шинээр бий болж тус хэргийн гаралт эрс нэмэгдэж байгаа тул тус хэргийн шалтгаан нөхцлийг олж тогтоох, илрүүлэх, тэмцэх арга замыг эрэлхийлж дүн шинжилгээ хийж, санал дэвшүүлэх зорилгоор тухайн сэдвийг сонгосон нь уг сэдвийг судлах үндэслэл болно.

Эл судалгааны ажлыг шинжлэх ухааны судалгааны аргын нэг болох тоон судалгааны аргыг ашиглаж, тэр дундаа статистикийн арга, индукцийн арга зэргийг ашиглаж хийсэн болно. Судалгааны арга зүйн зарчмын хувьд бодитой хандах, тогтвортой байх, зохистой байх зарчмыг баримталсан.

Кибер гэмт хэрэг буюу цахим орчинд цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн мөн чанар, ойлголт, өнөөгийн байдлын талаар эрдэм шинжилгээний цөөнгүй өгүүлэл нийтлэгдсэн. Тухайлбал, Л.Галбаатар "Кибер гэмт хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх нь" ном, Д.Булган "Кибер гэмт хэргийн мөн чанар, түүний шинжийг тодорхойлох нь", Б.Өнөрмаа "Цахим хэрэгсэл ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргийн шалтгаан нөхцөл, эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлага", Г.Мөнгөншагай "Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт", Д.Сумьяацэрэн "Монгол Улс дахь кибер гэмт хэргийн өнөөгийн байдал, дүгнэлт, санал", Б.Цэцэгмаа "Цахим гэмт хэрэгтэй тэмцэж буй өнөөгийн байдал, эрх зүйн зохицуулалт" зэрэг нэг сэдэвт бүтээлүүд гарч байсан байна.

Харин “Телеграм” платформ ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн үйлдлийн арга, шалтгаан нөхцлийг урьд өмнө нь судалж байгаагүй тул энэхүү судалгааг хийснээр судалгааны үр дүнд үндэслэн практикт тухайн гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох арга замыг тодорхойлох ач холбогдолтой, цаг үеэ олсон шинэлэг судалгаа болсон.

Abstract: With the development of modern techniques and technology in the world and the transition of all social relations to electronic form, the increasing use of the electronic environment by human beings gives society new opportunities for development, but also brings negative phenomena. One of the manifestations of this is the crime committed using the cyber environment.

Crimes committed using the cyber environment are committed through the borderless Internet environment, so the same type of crimes are committed in our country, they are evolving very intensively, and new methods of operation are regularly appearing.



Recently, fraud committed using the "Telegram" platform has been emerging in Mongolia, and the incidence of such cases has increased dramatically, so the subject was chosen for the purpose of analyzing and proposing ways to identify, detect, and combat the cause of the case.

This research work is done using quantitative research method, which is one of scientific research methods, including statistical method and induction method. In terms of research methodology, the principle of objectivity, stability, and appropriateness was followed.

Many academic articles have been published on the nature, concept, and current status of cybercrime, or crime committed using electronic tools in the online environment.

However, since the methods and causes of fraud committed using the "Telegram" platform have not been studied before, this research is useful and timely to determine ways to prevent, combat, and stop such crimes in practice based on the results of the research. innovative research.

Түлхүүр үгс: Телеграм платформ, кибер орчин, залилах гэмт хэрэг, дүн шинжилгээ.

Keywords: Telegram platform, cyber environment, fraud crimes, analysis.

Удиртгал

Олон улсын судалгааны "Datareportal" байгууллагаас жил бүр гаргадаг "DIGITAL 2024: MONGOLIA" судалгааны тайлангаар Монгол Улс 2024 оны эхний байдлаар 2.91 сая интернэт хэрэглэгчидтэй буюу нийт хүн амын 83.9 хувь нь интернэт ашигладаг гэх судалгаа гаргасан байна. (Simon, 2024) Энэ нь Монгол улсын хүн амын интернэтийн хэрэглээ хэр их байгааг харуулж байна.

Монгол улсын интернэт хэрэглэгчдийн тоо ихсэх тусам кибер орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн гаралт ихсэх хандлагатай байх бөгөөд сүүлийн үед "Телеграм" платформыг ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэрэг эрс нэмэгдэж байна.

Иймд кибер орчин ашиглан үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцлийг тодруулахаар телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргүүдийн судалгааг гаргаж, дүн шинжилгээ хийхэд уг өгүүлэгийн зорилго оршино.

Дээрх судалгааны ажлыг хийхдээ төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтээс телеграмм платформ ашиглан үйлдэгдсэн хэргийн судалгаа авч, тоон өгөгдлийг боловсруулж, үр дүнг тоон үзүүлэлтээр илэрхийлж, тоон мэдээлэлд үндэслэн дүгнэлт хийж, таамаглал дэвшүүлсэн болно.

Үндсэн хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт Монгол улсын иргэний өмчлөх эрхийг "...хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах,

эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй..." гэж хуулиар баталгаажуулсан байдаг. (Монгол Улсын Үндсэн Хууль, 1992)

Дээрхээс бусад тохиолдлоор бусдын эзэмшил, өмчлөлд байгаа аливаа хөрөнгийг өөрт авахыг гэмт явдал гэж үзэж болох бөгөөд гэмт явдал үйлдсэн этгээдийн учруулсан хор уршгаас шалтгаалж тухайн харилцаа тохирсон салбар хуулиудаар зохицуулагдана.

Өмчлөх эрхийн эсрэг гэмт явдалд тодорхой төрлийн үйлдлүүд хамаарах ба үүний нэг нь Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан "Залилах" гэмт хэрэг юм.

Монгол Улсын Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт залилах гэмт хэргийг "Хуурч, эсхүл баримт бичиг, эд зүйл, цахим хэрэгсэл ашиглаж, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох, сүсэг бишрэлийг далимдуулах, бодит байдлыг нуух замаар бусдыг төөрөгдөлд оруулж, эсхүл нэр хүнд, урьдын харилцааны явцад бий болсон итгэлийг урвуулан ашиглаж эзэмшигч, өмчлөгчийн эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг шилжүүлэн авсан..." гэж хуульчилсан байдаг. (Монгол Улсын Эрүүгийн Хууль, 2015)

Залилах гэмт хэргийн талаарх ойлголтыг зарим эрдэмтэд өөр өөрсдийн байр суурьнаас залилах гэмт хэргийн хөгжлийн үе шат бүрд янз бүрээр дараах байдлаар тодорхойлсон байна.

Академич, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор С.Нарангэрэлийн тодорхойлсноор Залилан





ХУУЛЬ САХИУЛАХУЙ

мэхлэх гэж өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүч хэрэглээгүй ашиглан шамшигдуулах хэлбэр. Залилан мэхлэх нь бусдын эд хөрөнгө, эсхүл түүний өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар авах. (Нарангэрэл, 2008, х.202)

Хууль зүйн ухааны доктор Д.Адъяабазарын тодорхойлсноор залилан мэхлэх гэмт хэрэг гэдэг нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдын өмчлөх эрхэд хуурч мэхлэх буюу итгэл эвдэх аргаар халдаж хохирол учруулсан, ял шийтгэгдвэл зохих, гэм буруутай Эрүүгийн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлд хуульчлагдсан нийгэмд аюултай, үйлдэл, эс үйлдэхүй юм. (Адъяабазар, 2004, х.64)

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ Б.Ганболдын тодорхойлсноор "Залилан мэхлэх авах" гэдэг нь эд хөрөнгө, мөнгө, үнэт зүйл, түүнийг өмчлөх эрхийг эзэмшиж, эрхлэн хариуцаж, харж хамгаалж байгаа этгээдийг хуурч мэхлэх буюу итгэлийг эвдэх замаар, шунахай сэдэлтээр авч буй идэвхитэй үйлдэл юм. Залилан мэхлэх буюу итгэл эвдэх замаар, шунахай сэдэлтээр авч буй идэвхитэй үйлдэл юм. (Ганболд, 2009, х.301)

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ С.Гантулга, Б.Энхболд нарын тодорхойлсноор залилах гэмт хэрэг гэж бусдын өмчлөх эрхэд гэм буруугийн санаатай хэлбэрээр халдсан, Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан нийгэмд аюултай, гэм буруутай үйлдэл (Гантулга & Энхболд, 2018, х.161) гэж тус тус тодорхойлсон байна.

Дээрх эрдэмтдийн тодорхойлолтуудаас үзэхэд залилах гэмт хэргийн ойлголт, мөн чанар хүн төрөлхтөний хөгжил дэвшлийн аль ч үе шатад алдагдалгүй өнөө үед ирсэн байна. Гагцхүү хүн төрөлхтөний хөгжил дэвшилтэй шууд холбоо хамааралтайгаар залилах гэмт хэргийн үйлдлийн арга хувьсан өөрчлөгдсөн нь ажиглагдаж байна.

Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт залилах гэмт хэрэг үйлдэх үйлдлийн аргыг зааж өгсөн байдаг тул бусад аргаар бусдын эд хөрөнгийг

авсан бол өмчлөх эрхийн эсрэг бусад гэмт хэргээр зүйлчлэгдэнэ.

Монгол Улсад үйлдэгдэж буй залилах гэмт хэргийг үйлдэгдэж буй арга хэлбэр талаас нь авч үзвэл:

- Урьдаас төлөвлөж иргэний эрх зүйн харилцааг ашиглан гэрээ, хэлцэл хийх замаар халхавчилж,

- Цахим хэлбэрээр буюу олон нийтийн сүлжээ ашиглаж улс дамнаж;

- Өөрийн ажил, мэргэжил, авъяас чадвар, нэр хүндээ ашиглаж;

- Гадаадад ажиллах хүч гаргахад зуучлах нэрээр, мөн Монгол улсын цалин хангамж өндөртэй аж ахуй нэгж байгууллагуудад ажилд оруулж өгнө гэж амлаж;

- Урьдын харьцааг урвуулан шашин шүтлэг, сүсэг бишрэл, хобби, танил талын хүрээллийг ашиглаж;

- Олон шатлалт маркетинг, пирамид тогтолцооны луйврын аргаар;

- Эрх зүйн олон төрлийн харилцаа болон нийгэм, эдийн засгийн харилцааг холилдуулан гадаад дотоодын хөрөнгө оруулагч, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг залилах ... гэх мэт олон төрлийн арга хэлбэрээр энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэж байна.

21-р зуунд хүн төрөлхтөний хамгийн том дэвшлийн нэг нь кибер орчны хэрэглээ бөгөөд үүнийгээ дагаад гэмт хэргүүд ч мөн адил цахим хэлбэр рүү шилжиж кибер гэмт хэргийн талаарх ойлголтууд бий болсон.

Дэлхийд хамгийн анх бүртгэгдсэн кибер гэмт хэрэг 1820 онд үйлдэгдсэн гэж үздэг. Францын нэхмэлийн үйлдвэрийн эзэн Жозеф Мари Жаккард нэхмэлийн суурь машин хийсэн нь ажилтнуудыг ажилгүй болгох эрсдлийг дагуулж байна гэж үзсэн зарим ажилтан уг төхөөрөмжийг ажиллагаагүй болгох гэмт хэрэг үйлдсэн нь анхны кибер гэмт хэрэг гэж тооцогддог. (Халтар, 2018)

"Кибер гэмт хэрэг" гэсэн нэр томъёо нь 1986 онд мэдээллийн системийн хөгжилтэй холбоотой үүссэн ч улс орнуудын эрх зүйн зохицуулалт, эрдэмтэн судлаачдын бүтээлд "Цахим гэмт хэрэг", "Компьютерын гэмт хэрэг", "Кибер аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг" гэх мэт

олон нэр томьёо хэрэглэдэг. Компьютерын гэмт хэрэг буюу хууль бус зорилгодоо хүрэхийн тулд компьютер, компьютерын сүлжээ, интернет ашиглан үйлдэж буй хууль бус үйлдлийг хамтатган "Кибер гэмт хэрэг" гэж нэрлэх болсон. (Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН, 2002, х.15)

Сүүлийн жилүүдэд кибер гэмт хэргүүд уламжлалт гэмт хэргээс тоо, хохирлын хувьд давж гарах болсон байна. Эрсдэл болон зардал бага, унац ихтэй тэр газарт түүнийг ашиглах гэсэн хүмүүс борооны дараах мөөг шиг олширдог. Яг энэ байдал кибер орон зай, Интернетийн орчинд үүсээд байна. Компьютер, мэдээллийн технологийн багахан ч гэсэн мэдлэг чадвартай, ашиг олохыг хүссэн, шударга бус хэн бүхэн энэ орон зайг ашиглан ашиг олохын төлөө улайран зүтгэх болсон. Түүнээс гадна энэ чиглэлийн эрх зүйн орчин сул, зарим улсад огт бүрэлдэн тогтоогүй, компьютер, тооцоолох төхөөрөмж, програм хангамжид эмзэг сул байдал, цоорхой их байдаг, байгууллага, хүмүүс мэдээллийн аюулгүй байдлаа хангах, сүлжээ, интернетэд зөв, зохистой ажиллах чадвар, мэдлэг, туршлага муутай, кибер орчинд ул мөр бага үлддэг, нотлох баримт нь тогтвортой бус, бэхжүүлж авахад хүндрэлтэй, хууль хяналтын байгууллагуудын чадвар төлөвшөөгүй, чадварлаг мэргэжилтэн ховор зэргээс илрэх магадлал нь уламжлалт гэмт хэргүүдээс хэд дахин бага байдаг нь кибер гэмт хэрэгтнүүдийн дураараа аашлах боломжийг олгож байна. (Халтар, 2018)

Будапештийн конвенцод компьютерын мэдээлэл, сүлжээний эсрэг гэмт хэрэг, компьютерын мэдээлэл, сүлжээний тусламжтай үйлдсэн гэмт хэрэг гэх хоёр шинжийг хамтатган кибер гэмт хэргийг тодорхойлж, түүнийг дөрвөн төрөлд ангилсан. Будапештийн конвенцын хоёрдугаар бүлгийн "Эрүүгийн материаллаг хууль" гэх нэгдүгээр хэсэгт 4 төрөл, нийт 9 гэмт хэргийг тусгасан. Үүний нэг нь кибер орчин ашиглаж үйлдсэн залилах гэмт хэрэг юм. (Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН, 2002, х.17)

Манай улсын хувьд энэ оны эхний 09 сарын байдлаар цагдаагийн байгууллагад

нийт 24,811 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж байна. Залилах гэмт хэрэг 7063 буюу нийт гэмт хэргийн 28.5% хувийг эзэлж байгаа бол үүнээс 4095 буюу 58% хувь нь кибер орчинд үйлдэгдэж байна. (ЦЕГ-ын МДШШУА, 2024)

Дээрх судалгаанаас дүгнэхэд кибер орчинд үйлдэгдсэн залилах гэмт хэргийн үйлдлийн аргууд хурдацтай шинэчлэгдэн, хувьсаж тасралтгүй нэмэгдэж байгаа бөгөөд 2030 он гэхэд энэ төрлийн гэмт хэрэг 30,000 бүртгэгдэж оргил үедээ хүрэх эрсдэлтэй прогноз гарч байна.

Иймд сүүлийн үед кибер орчин ашиглан ихээр үйлдэгдэж байгаа залилах гэмт хэргийн нэгэн төрөл болох телеграм платформ ашиглан үйлдсэн залилах гэмт хэргийн гаралт, шалтгаан нөхцлийг судалж, таслан зогсоох шаардлага нэн тэргүүнд тулгараад байна.

"Телеграм" платформыг ОХУ-ын иргэн Павел Дуров, Николай Дуров нар 2013 онд үүсгэн байгуулсан. Телеграм платформ нь 950 сая гаруй идэвхтэй хэрэглэгчидтэй бөгөөд дэлхийн хүн амын хамгийн их ашигладаг программын нэг юм. Телеграм нь аюулгүй байдал, нууцлалыг нэгдүгээрт тавьдаг учраас энэ нь тус платформыг хэрэглэгчдийн тоог тасралтгүй нэмэх гол шалтгаан болдог байна.

Телеграм нь өөрийн өвөрмөц хамгаалалтын функцтэй бөгөөд телеграм дээрх бүх үйл ажиллагаа, түүний дотор хэрэглэгчдийн хооронд хуваалцсан чат, групп, медиа шифрлэгдсэн байдаг тул эхлээд шифрийг нь тайлахгүйгээр харагдахгүй гэсэн үг юм. (Telegram, 2013)

Монгол улсад телеграм платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргийн судалгааг гаргахад цагдаагийн байгууллагад нийт 277 бүртгэгдэн, шалгагдаж байгаа бөгөөд нийт 277 хохирогчид 3,991,894,493 төгрөгний хохирол учруулсан нөхцөл байдалтай байна. Нутаг дэвсгэрээр задлан харуулбал:

Орон нутгийн хэмжээнд:

Телеграм платформд үйлдэгдсэн нийт залилах гэмт хэргийн 77 буюу 27.8% нь орон нутагт үйлдэгдсэн байх бөгөөд 1,435,009,822 төгрөгний хохирол учруулсан байна.





МОНГОЛЫН
Дотоодын
Хэрэг
Яам




Зураг 1. Орон нутгийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг

Нийслэлийн хэмжээнд:


Нийслэлийн хэмжээнд 200 буюу 72.2% нь үйлдэгдсэн байх бөгөөд 2,556,881,671 төгрөгний хохирол учруулсан байна.

Зураг 2. Нийслэлийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг



Telegram платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэргийн хохирогчдын талаар:

Цагдаагийн байгууллагад шалгагдаж байгаа нийт telegram платформд үйлдэгдсэн залилангийн 65% буюу 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Мөн нийт хохирогчдын 69%-ийг 25-44 насны залуучууд эзэлж байна.



Зураг 3. Хохирогчдын нас, хүйс

Хохирогчдыг нийгмийн оролцоогоор нь ангилан авч үзвэл нийт хохирогчдын 45% хувь нь хувийн хэвшилд буюу /ченж, уурхайн оператор, мужаан, хүргэлтийн ажилтан, үсчин, менежер, засварчин, тогооч г.м/ ажил, хөдөлмөр эрхэлдэг хүмүүс эзэлж байна.



Зураг 4. Хохирогчдын нийгмийн байдал

Хохирогчдыг боловсролын түвшнээр нь ангилан авч үзвэл 14 буюу 5%-ийг бага дунд, 92 буюу 33%-ийг бүрэн дунд, 172 буюу 62%-ийг дээд боловсролтой хүмүүс эзэлж байна.



МОНГОЛЫН ИРГЭДНИЙ
ХАМГААГАХ ЯАМ



Хууль сахиулахуй

Боловсролын түвшин:



14 буюу 5%

**Бага, дунд
боловсролтой**



92 буюу 33%

**Бүрэн, дунд
боловсролтой**



172 буюу 62%

**Дээд
боловсролтой**

Нийт хохирогчдын
боловсролын түвшинг
харьцуулан харуулбал

Зураг 5. Хохирогчдын боловсрол

Telegram платформд үйлдэгдсэн хэргүүдийн үйлдлийн аргуудад дүн шинжилгээ хийхэд дараах 6 төрлийн аргаар гэмт хэрэг үйлдэж байгаа нь тогтоогдсон. Үүнд:

1. Бараа худалдан авч, борлуулалт нэмэгдүүлэх даалгавар **158 (57%/)**
2. Тик ток хаяг дагах, өгөгдсөн постод лайк дарж хандалт өсгөх даалгавар **44 (15.8%)**
3. Байгууллагын үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, зар сурталчилгаанд үнэлгээ өгөх даалгавар **39 (14%)**
4. Өгөгдсөн дансанд мөнгө байршуулаад өсгөж авах даалгавар **31 (11.1%)**
5. Зээл олгоход шаардлагатай материал бүрдүүлэх даалгавар **3 (1.08%)**
6. Өгөгдсөн интернэт банкаар нэвтэрч гүйлгээ хийх даалгавар **2 (1.02%)** тус тус эзэлж байна.

Дүгнэлт, санал

Цагдаагийн байгууллагад telegram платформ ашиглан үйлдэгдсэн залилах гэмт хэрэг энэ оны 07 дугаар сараас хойш 277 бүртгэгдэн, шалгагдаж байгаа бөгөөд 3,991,894,493 төгрөгний хохирол учруулсан байгаагаас дүгнэхэд оны эцэст энэ төрлийн гэмт хэрэг 1000 гаруй бүртгэгдэж 12 тэрбум төгрөгний хохирол учруулж болзошгүй байна.

Иймд энэ төрлийн гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдэд кибер орчинд үйлдэгдэж буй залилах гэмт хэргийн талаарх ойлголтыг бий болгох, түүнээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн арга

хэмжээг зөв, оновчтой хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна.

Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид нь 25-44 насны залуучууд байх бөгөөд 3 хохирогч тутмын 2 нь эмэгтэй хүн байна. Гэмт этгээдүүдийн чиглэсэн сегмент нь амар хялбар аргаар санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх гэсэн тогтвортой орлогогүй эмэгтэйчүүд тэр дундаа хүүхдээ гэртээ асардаг залуу ээжүүд байж болзошгүй нөхцөл байдал ажиглагдаж байна.

Мөн telegram платформ хэрэглэгчдийг автоматаар групп чатанд нэмж, тухайн групп чатаараа дамжуулж иргэдийг төөрөгдөлд оруулсан амар хялбар аргаар мөнгө олох боломжтой мэт худал мэдээлэл дамжуулж итгэл үнэмшил төрүүлж байгаа нөхцөл байдал тогтоогдсон.

Олон улсад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх технологийн шийдэл, арга замыг хараахан олж тогтоогоогүй байгаа ба одоогийн байдлаар иргэд олон нийт рүү чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Үүний нэг илрэл нь telegram платформ хэрэглэгчдэд танихгүй хэрэглэгчдээс зурвас, хүсэлт хүлээн авахгүй байх хувийн тохиргоо хийхийг зөвлөж байгаа явдал юм.

Иймд олон улсад telegram платформ ашиглан үйлдэгдэж буй гэмт хэргээс

урьдчилан сэргийлэх зорилгоор ашиглаж буй тус аргыг ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх газраар дамжуулан иргэд олон нийтэд сурталчилж урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулах,

Telegram платформ ашиглан үйлдэгдэж байгаа залилах гэмт хэрэгтэй тэмцэж буй гадаад улс орны туршлагыг судлан өөрийн оронд нэвтрүүлэх,

Гадаад улс орны туршлага дээр суурилж telegram платформд үйлдэгдсэн залилах гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох дагнасан чиг үүрэг бүхий мэргэшсэн мөрдөгч бэлтгэх,

Мөрдөн шалгах ажиллагаанаас үүдэн гэмт этгээдүүд хууль бусаар олсон хөрөнгийг гадаад улс руу гаргасан бол эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээний дагуу тухайн улстай хамтран мөрдөн шалгах ажиллагааг үргэлжлүүлэх саналтай байна.

Эх сурвалж

Монгол Улсын Их Хурал. (1992). Монгол Улсын Үндсэн Хууль. Улаанбаатар.

Монгол Улсын Их Хурал. (2015). Монгол Улсын Эрүүгийн Хууль. Улаанбаатар.

Адъяабазар, Д. (2004). Монгол Улсад залилан мэхлэх гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцлийн тулгамдсан асуудал сэдэвт докторын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар.

Ганболд, Б. (2009). Эрүүгийн эрх зүйн мэдлэг. Улаанбаатар.

Гантулга, С., & Энхболд, Б. (2018). Эрүүгийн эрх зүй тусгай анги. Улаанбаатар.

Нарангэрэл, С. (2008). Эрх зүйн эх толь бичиг. Улаанбаатар: Соёмбо принтинг.

Өмгөөллийн Фиделитас Партнерс ХХН. (2002). Кибер гэмт хэргийн зохицуулалтын талаарх харьцуулсан. Улаанбаатар.

Халтар, Т. (2018). Өмчлөх эрхийн эсрэг кибер гэмт хэрэг, урьдчилан сэргийлэх асуудлууд нэг сэдэвт бүтээл. Улаанбаатар.

ЦЕГ-ын МДШШУА. (2024). Гэмт хэргийн статистик. Улаанбаатар.

Simon, K. (2024). Digital 2024:Mongolia. Singapore.

Telegram. (2013, 8 14). Retrieved from <https://telegram.org/>

